



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠖ оны ᠐᠘ сарын ᠒᠑ өдөр

Дугаар А/᠕᠕

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 151 дүгээр сургуулийн хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/595 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бараа материалын дансанд бүртгэлтэй нийт 94,447,300.00 (ерэн дөрвөн сая дөрвөн зуун дөчин долоон мянга гурван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 151 дүгээр сургууль (П.Хувьзаяа)-д зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 151 дүгээр сургууль (П.Хувьзаяа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА



Нийслэлийн өмчийн харилцааны газрын
даргын 2026 оны 02 дугаар сарын 03.....-ний
өдрийн АИМ... дүгээр тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын 151 дүгээр сургууль

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо	Бүртгэх анхны		Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр		
						Нэгжийн үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс	
1	Контент	10/31/2024	сайн	ш	2	14,175,000.00	28,350,000.00	6,615,000.00	21,735,000.00	Машин тоног төхөөрөмж	Программ хангамж	
2	Гэрлэн гарц	10/31/2024	сайн	ш	2	25,000,000.00	50,000,000.00	11,666,666.62	38,333,333.38	Машин тоног төхөөрөмж	Бусад үндсэн хөрөнгө	
3	Зөөврийн агуулах /контейнер/	7/30/2025	сайн	ш	1	15,000,000.00	15,000,000.00	625,000.00	14,375,000.00	Тавилга, эд хогшил	Бусад үндсэн хөрөнгө	
4	Цаас бутлагч	1/1/2020	сайн	ш	2	338,650.00	677,300.00	-	677,300.00	Бараа материал	Машин тоног төхөөрөмж	
5	Баримт үдэгч машин	1/1/2020	сайн	ш	2	150,000.00	300,000.00	-	300,000.00	Бараа материал	Машин тоног төхөөрөмж	
6	Нуруулдагч	1/1/2020	сайн	ш	1	120,000.00	120,000.00	-	120,000.00	Бараа материал	Тавилга эд хогшил	
								94,447,300.00	75,540,633.38			
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн												